



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/147

Булган сум

┌ Эзэмшил газрын зориулалт өөрчлөх тухай ┐

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн IX/19 дүгээр тогтоолоор баталсан “Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Л.Цэвэг-Очир (ГЭ65010413)-ын Булган сум 5 дугаар баг Л.Энэбиш 2 дугаар гудамж 203 тоотод байршилтай 6308003664 нэгж талбар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 1511 м² газрын зориулалтыг үйлчилгээтэй орон сууц болгон өөрчилсүгэй.

2. Л.Цэвэг-Очиртой газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны А/373 дугаар захирамжийн Л.Цэвэг-Очиртой холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

